



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2018. 04.16 № 21

Асуулга тавих тухай

Монгол Улс нь хүүхдийн эрхийн асуудлыг анхааралдаа авсан улс орнуудын тоонд дээгүүрт жагсдаг бөгөөд 1989 онд гарсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг баталсан эхний 10 улсын тоонд ордог. Мөн Хүүхдийн эрхийн бусад конвенц, хөтөлбөрт нэгдэн орсон. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрх, Хүүхдийн хамгааллын тухай хууль тогтоомжийн дагуу болон Олон улсын өмнө хүүхдийн эрхийг хангах, хамгаалах бүхий л үүргийг Засгийн газар хүлээж байгаа. Гэтэл сүүлийн жилүүдэд хүүхдийн хүчирхийллийн холбоотой асуудал гэмт хэрэг буурахгүй байгаа, урьд өмнө гарч байгаагүй хүнд, шинэ төрлийн хүчирхийллийн хэлбэрүүд бий болж байгаа, бэлгийн хүчирхийлэл тэр дундаа бага насны хүүхдийн хүчирхийллийн асуудал ойр ойрхон гарч нийгмийн цочирдуулах болсон зэрэгтэй холбогдуулан Танд дараах асуулгыг тавьж байна.

Үүнд:


1. Хүүхдийн хүчирхийллийн эсрэг Засгийн газрын зүгээс хийсэн судалгаа, хэрэгжүүлж байгаа ажлуудын талаар;
2. Засгийн газрын зүгээс хүүхдийн хүчирхийллийн үндсэн шалтгаан юу болох талаар судалгаа гаргасан эсэх;
3. Хүүхдийн хүчирхийллийн гол нөхцөл буруутан нь ойр дотны, тэдгээрийн хүрээний хүмүүс тэдний архидалт зугаа цэнгээнээс болж байгаа нь судалгаанаас гарсан байна. 2017 онд батлагдсан зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн ямар байгаа талаар;
4. Хүний эрхийн үндэсний комиссын судалгаагаар Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд нөлөөлж байгаа үндсэн хүчин зүйлс нь i) Санхүүгийн бэрхшээл, ii) Эцэг эх олон нийтийн буруу хандлага, iii) Арга зүйн мэдлэг хамтын ажиллагаа сул, зохицуулалт муу, цаг зав гардаггүй гэсэн шалтгаанууд гарсан байдаг. Үүнтэй холбоотойгоор болон хүүхэд хамгааллын ажлыг сайжруулах хүрээнд Засгийн газрын зүгээс ойрын хугацаанд юу хийж байгаа талаар;

Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал бүрэн сайжраагүй, ард түмний амьжиргаа хүнд байгаагийн хажуугаар хүүхдийн хүчирхийллийн асуудал нь нийтийн санааг зовоох гол асуудал гэж үзэж байгаагийн хувьд энэ талаар таныг тодорхой тооцоо, судалгаатай, хэрэгжүүлэх бодитой арга хэмжээг дурдсан хариулт өгөхийг хүсч байна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэх, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонгохыг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



М.ОЮУНЧИМЭГ